



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024. 04. 25 № 1068

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай \_\_\_\_\_

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Иргэний хөдөлгөөний нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Иргэний хөдөлгөөний нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Иргэний хөдөлгөөний нам"-ын мөрийн хөтөлбөр /.....9.....хууль/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030690

"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.



## ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН "НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ" СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### 1) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН "НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ" СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Иргэний хөдөлгөөний намын Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн үндэслэл:

- "Иргэний хөдөлгөөний" гэх улс төрийн нам нь үндэснийхээ эрх ашгийг дээдлэн, ард түмнийхээ Монгол Улсын "Үндсэн Хууль"-аар олгогдсон Улс төрийн хуульчлагдсан эрх ашгийг хамгаалан, Иргэний хөдөлгөөний намын гишүүдийнхээ Монгол Улсын "Үндсэн Хууль"-аар олгогдсон улс төрийн хуульчлагдсан эрх ашгийг төлөөлөн Монгол Улсын бүхий л хууль тогтоомжуудыг ёсчлон сахиж, хуулиар олгогдсон улс төрийн эрх, үүрэг, хариуцлагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэн ажиллах болно

гэж илэрхийлснийг Иргэний хөдөлгөөний намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн ерөнхий үндэслэл гэж үзнэ.

*B. Battal*

00000001



## 2) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН "НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ" СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХУУЛЬ ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль ёс зүйн зарчим:

- Монгол Улсын "Үндсэн Хууль", Монгол Улсын "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ыг дээдлэн сахиж, дагаж мөрдөн ажиллана;
- Монгол Улсын төрийн бүрэн бүтэн байдал, засаглалын залгамж чанарыг дээдлэн сахиж ёсчлон биелүүлж ажиллана;
- Улс орныхоо эрх ашиг, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг дээдлэн сахиж хариуцан хамгаалж ажиллана;
- Үндэсний эрх ашиг, үндэсний эв нэгдлийг дээдлэн сахиж, батлан хамгаалж ажиллана;
- Ард түмний эрх ашиг, ард түмний эв нэгдийг дээдлэн сахиж, хайрлан хамгаалж ажиллана;
- Хүний эрх, эрх ашиг, хүн төрөлхтөний эв нэгдлийг дээдлэн сахиж нийтлэг хууль ёс, ёс зүй, ёс суртахуун, өөрийн болон бусад олон улс үндэстнүүдийн ёс, зан заншлыг хүндэтгэн эрхэмлэж ажиллана;
- Хөрш улс орон болон бусад гадаад улс орнуудын эрх ашиг, дэлхийн бүхий л улс орнуудын хамтын эв нэгдлийг дээдлэн сахиж харилцан үр ашигтай хамтран ажиллана;
- Улс орон, хүн ардынхаа өмнө хүлээсэн хуульчлагдсан эрх үүрэг хариуцлагаа дээдлэн сахиж нэр төртэйгөөр бүрэн төгс биелүүлж ажиллана;
- Дэлхийн хүн төрөлхтөний нэгдэн оршихуйн өмнө хүлээсэн үүргээ бүрнээ хүлээн зөвшөөрч хүн байгалийн хүйн холбоо байгаль экологийн тэнцвэртэй тогтвортой хөгжлийг дээдлэн сахиж бүрэн дүүрэн ханган ажиллана;
- Шинжлэх ухааны бүхий л хэм хэмжигдэхүүнээр нотлогдсон үндэсний эрх зүй нь улс хөгжихийн үндэс болохыг дээдлэн сахиж баримтлан ажиллана;
- Хууль эрх зүйн бүхий л хэм хэмжигдэхүүнээр батлагдсан хөдөлмөрлөх эрх зүй нь нийгэм хөгжихийн үндэс болохыг дээдлэн сахиж баримтлан ажиллана;

*B. Battal*


00000002

"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав



- Улс төрийн намуудын эрх ашиг, улс төрийн намуудын эв нэгдлийг дээдлэн сахиж, эрх тэгш хамтран ажиллана;
- Иргэний хөдөлгөөний намын гишүүдийнхээ эрх ашиг, эв нэгдлийг дээдлэн сахиж, бататган бэхжүүлж ажиллана

гэж илэрхийлснийг Иргэний хөдөлгөөний намын Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль ёс зүйн ерөнхий зарчим гэж үзнэ.



*B. Battal*

00000003

"ИХ" намын Элжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.



**3) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН  
"НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ"  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ**

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн зарчим:

Иргэний хөдөлгөөний нам нь хуулиар олгогдсон улс төрийн эрх, үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэхдээ:

- Монгол Улсын "Үндсэн Хууль", Монгол Улсын бүхий л хууль тогтоомжуудыг хуульчлан сахиж,
- Монгол Улсын "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ыг ёсчлон сахиж,
- "Монгол Улсын улс төрийн намуудын тухай хууль"-ийг хуульчлан биелүүлж,
- Монгол Улсын "Төсвийн тогтвортой байдлын тухай хууль" болон холбогдох бүхий л хууль тогтоомжуудыг хуульчлан мөрдөж,
- Монгол Улсын Их Хурлаар батлагдсан "Алсын Хараа-2050" "Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого"-д нийцүүлэн,
- "Монгол Улсын Аудитын тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган,
- "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль"-ийг хуульчлан хэрэгжүүлж ажиллах болно

гэж илэрхийлснийг Иргэний хөдөлгөөний намын Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хууль эрх зүйн ерөнхий зарчим гэж үзнэ.

"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.



**4) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН  
"НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ"  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

**ЕРӨНХИЙ ЗОРИЛГО**


**"Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн  
бодлогын хэрэгжилтийг хангах**

**"Үндэсний хөгжлийн нэгдсэн эрх зүйн орчин"-г  
хуульчлан баталгаажуулах**

**ЗОРИЛГО 1.**

**Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын хэрэгжилтийг хангах**

**"Үндэсний соёлын хөгжлийн нэгдмэл эрх зүйн орчин" -г  
хуульчлан баталгаажуулах**



**ЗОРИЛГО 2.**

**Хүний хөгжил бодлогын хэрэгжилтийг хангах**

**"Монгол хүний хөгжлийн нэгдмэл эрх зүйн орчин" -г  
хуульчлан баталгаажуулах**

**ЗОРИЛГО 3.**

**Амьдралын чанар ба дундаж давхрага бодлогын хэрэгжилтийг  
хангах**

**"Амьдралын чанарын хөгжлийн нэгдмэл эрх зүйн орчин" -г  
хуульчлан баталгаажуулах**

*B. Battal*

00000005

"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.



**ЗОРИЛГО 4.**

ЭДИЙН ЗАСАГ бодлогын хэрэгжилтийг хангах

**"ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"-г  
ХУУЛЬЧЛАН БАТАЛГААЖУУЛАХ**

**ЗОРИЛГО 5.**


ЗАСАГЛАЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**"ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛЫН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"-г  
ХУУЛЬЧЛАН БАТАЛГААЖУУЛАХ**

**ЗОРИЛГО 6.**

НОГООН ХӨГЖИЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**"БАЙГАЛЬ ЭКОЛОГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"-г  
ХУУЛЬЧЛАН БАТАЛГААЖУУЛАХ**



**ЗОРИЛГО 7.**

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ бодлогын хэрэгжилтийг хангах

**"НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"-г  
ХУУЛЬЧЛАН БАТАЛГААЖУУЛАХ**

**ЗОРИЛГО 8.**

БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ бодлогын хэрэгжилтийг хангах

**"БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"-г  
ХУУЛЬЧЛАН БАТАЛГААЖУУЛАХ**

*B. Battal*

00000006

"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.




**ЗОРИЛГО 9.**

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ бодлогын хэрэгжилтийг хангах

**"НИЙСЛЭЛ ХОТЫН ХӨГЖЛИЙН НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"-г  
ХУУЛЬЧЛАН БАТАЛГААЖУУЛАХ**

**НЭГДСЭН ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖЛИЙН  
ТӨЛӨӨ!**



*B. Battal*

00000007



"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 сугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.



**5) ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН  
"НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖИЛ"  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛБАР**

Монгол Улс 1992 оны "Үндсэн хууль"-раа дэлхийн хүн төрөлхтөний ирээдүйн нэгдмэл хөгжлийн суурь үзэл баримтлал, тулгуур зарчмуудыг дээдлэн сонгож, "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-ыг хүлээн зөвшөөрч, нэгдэн, ардчиллын үзэл санаанд тулгуурлан хөгжих цоо шинэ хөгжлийн зам мөрийг хуульчлан баталгаажуулсан.

Энэхүү үнэт зүйл, үзэл санааны хувьд эрс ялгаа, онцлог бүхий нийгмийн шилжилтийн түүхэн зайлшгүй нөхцөлд Монгол Улс ардчилсан нийгмийн үндэс суурийг баталгаажуулах, нийгэм-улс төр, нийгэм-эдийн засгийн хөгжлийн суурь асуудлуудыг шийдвэрлэх хүнд сорилттой тулгарсан юм.

Өнгөрсөн хугацаанд эдгээр сорилтуудыг даван туулах зорилгын хүрээнд УИХ-аас нийгмийн хөгжлийн зорилго зорилтуудыг тодорхойлсон бодлогын баримт бичгүүдийг үе шаттайгаар баталж хэрэгжүүлж ирсэн. Үүнд:

- 1) 1996 онд УИХ-ын 26-р тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал";
- 2) 1998 онд Засгийн газрын 82-р тогтоолоор "Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр";
- 3) 2001 онд УИХ-н 57-р тогтоолоор "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал";
- 4) 2008 онд УИХ-н 12-р тогтоолоор "Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого";
- 5) 2016 онд УИХ-н 19-р тогтоолоор "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030";
- 6) 2020 онд УИХ-н 52-р тогтоолоор "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого байна.

Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх түүхэн үйл явцын нийтлэг үр дүнгээр Монгол Улс нийгмийн шилжилтийн үе шатыг амжилттай даван туулж, урт хугацааны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэх хөгжлийн зорилтот үе шатруугаа дэвшин орох цаг боллоо хэмээн Иргэний хөдөлгөөний нам дүгнэж байна.

Шилжилтийн үед гарсан гажуудал завхралын уг шалтгааныг шинжлэх ухааны үндэстэй судлан дүгнэж түүхэн сургамж болгох, цаашид дахин алдахгүй байх нөхцөл байдлыг хууль эрх зүйн орчноор баталгаажуулах нь зайлшгүй нэхэгдэж буй цаг үеийн шаардлага мөн.

00000008

"ИХ" намын Ээлжит бус III Иргэний Бага  
Чуулганы 2024 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 09 тоот тогтоолоор батлав.



Туулсан бүхнээ нэгтгэн дүгнэж, өнгөрсөн цагийн алдаа оноо ирэх цагийн сургамж байх бодит үнэнийг хүлээн зөвшөөрч, чи-би гэж талцахгүй, миний-чиний гэж булаацалдахгүй, хүний-өөрийн гэж ялгалгүй, манай-танай гэж хуваалгүй, их-бага гэж гололгүй, дээр-доор гэж үзэлгүй үндэсний эрх ашгаа дээдлэн, харилцан ойлголцож, хамтын хүчээр бүтээн байгуулах, улс орныхоо ирээдүйн төлөө бүх нийтээрээ, бүхий л түвшинд, эвлэлдэн нэгдэх цаг боллоо.

Иймд дээрх "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд төрийн бүрэн бүтэн байдал, засаглалын залгамж чанараар баталгаажигдах хөгжил дэвшлийн төлөө нэгдэн нийлж Монгол Улсынхаа ирээдүйг хамтдаа бүтээн байгуулах их үйл хэрэг нь Монголын ард түмэн, төр засаг, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, хуулийн этгээд, хувь иргэн бүрийн эдлэх эрх, хэрэгжүүлэх үүрэг, хүлээх хариуцлага болж байна.

"Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогоор дэвшүүлэн тавигдсан дараах:

- 1) Үндэсний нэгдмэл үнэт зүйл;
- 2) Хүний хөгжил;
- 3) Амьдралын чанар ба дундаж давхрага;
- 4) Эдийн засаг;
- 5) Засаглал;
- 6) Ногоон хөгжил;
- 7) Амар тайван, аюулгүй нийгэм;
- 8) Бүс орон нутгийн хөгжил;
- 9) Улаанбаатар ба дагуул хот;

Дээрх үйл хэргийг хэрэгжүүлэх "Үндэсний хөгжлийн нэгдсэн удирдлагын тогтолцоо"-г эрх зүйчлэх, нэгдмэл эрх зүйн орчныг хуульчлан баталгаажуулах хэрэгтэй болов.

2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дүнгээр шинээр байгуулагдах УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд "Үндэсний хөгжлийн нэгдсэн удирдлагын тогтолцоо"-г эрх зүйчлэх, нэгдмэл эрх зүйн орчныг хуульчлан баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын ирээдүйн хөгжлийг бүтээн байгуулах үндэс суурь нь "Үндэсний хөгжлийн нэгдмэл эрх зүйн орчин"-г хуульчлан баталгаажуулах зайлшгүй үйл хэрэг мөн.

**НЭГДМЭЛ ЭРХ ЗҮЙТ МОНГОЛ ХӨГЖЛИЙН  
ТӨЛӨӨ!**

*B. Battal*

00000009